

ТАНИЛЦУУЛГА

Жагсаалт, журам батлах тухай
Засгийн газрын тогтоолын төсөл
боловсруулсан тухай

2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр

Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5-д “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагаас хамааралтайгаар ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 2.8 хүртэл хувиар ялгавартай тогтоох бөгөөд ялгавартайгаар шимтгэл төлөх ажил олгогчийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан Засгийн газар тогтооно” гэж заасан.

Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолоор хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн ослын даатгалын шимтгэлийн жагсаалтыг баталж 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн одоог хүртэл мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага, эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос ялгавартай тогтоох бөгөөд шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээ, хэрэглэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална” гэж заасан.

Хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Жагсаалт, журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар баталсан “Үндэсний ажил мэргэжлийн ангилал, ба тодорхойлолт “YAMAT”-08”-ыг баримтлан боловсруулав.Төсөлд тусгаснаар 1,5 хувиар шимтгэл төлөх 456 ажил мэргэжил, 2,5 хувиар төлөх 351 ажил мэргэжил байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 2023 оны орлого 244.4 тэрбум төгрөг, зарлага 80.2 тэрбум төгрөг байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2022 онд 7 259 хүнд 40.6 тэрбум төгрөг зарцуулсан байна. Үйлдвэрлэлийн ослын даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ялгавартай төлсөн ажил олгогчийн тоо 2022 онд 0.8 хувиар 39 155, 1.8 хувиар 13 813, 2.8 хувиар 2 448 байна. Үйлдвэрлэлийн ослын даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ялгавартай төлсөн даатгуулагчийн тоо 2022 онд 0.8 хувиар 787 437 (64,1 тэрбум төгрөг), 1.8 хувиар 251 413 (49,7 тэрбум төгрөг), 2.8 хувиар 155 766 (90,6 тэрбум төгрөг) байна. 2023 оны 9 дүгээр сарын байдлаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн үлдэгдэл 510 тэрбум төгрөг байна.

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар ажил олгогч, даатгуулагч хууль тогтоомжийг нэг мөр ойлгож мөрдөх ба тогтоолыг хэрэгжүүлэхэд нийгмийн даатгалын сангийн төсөв 5.9 тэрбум төгрөгөөр буурна.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ